



БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ ДЭХ
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/33


Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дэх зүйлийн 14.4.2, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгдийн 2014 оны 66 дугаар тогтоолын 5 дах хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 519,900 / таван зуун арван есөн мянга есөн зуун / төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтанд заасан үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлтэй орлогод авахыг нягтлан бодогч /цагдаагийн ахлах дэслэгч Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Шинээр бий болсон эргэлтийн бус хөрөнгийн эзэмшилт, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга /цагдаагийн ахмад Т.Мөнхзул/-д үүрэг болгосугай.
4. Холбогдох бичиг баримтын бүрдэлийг хангаж ажиллахыг нярав /цагдаагийн дэд ахлагч Н.Оюунтуяа/-т даалгасугай.
5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.ЛХАГВАСҮРЭН



11265

Хэлтсийн даргын 2020 оны ... дугаар
сарын ... ний өдрийн ... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



**БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ШААРДЛАГАТАЙ
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

Д/д	Бараа материалын нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Үнэ
1	Хөргөгч / littleswan /	175 литр багтаамжтай	1	519,900
НИЙТ ДҮН			1	519,900

БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС